



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Алтай Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 50,100,010.00 (тавин сая нэг зуун мянга арван) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Алтай Улиастайн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Пүрэвсүрэн, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

  
Б. ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

  
А. АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн  
А.Б.Б. дугаар тогтоолын хавсралт



"Алтай Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн балансаас  
"Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн балансад  
шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Цахилгаан дамжуулах дэд шугам	2004.12.31	ш	1	40,300,010.00	40,300,010.00	0
2	Ил дэд станц	2001.07.07	ш	1	9,800,000.00	9,800,000.00	0
	<b>НИЙТ ДҮН:</b>				<b>50,100,010.00</b> (тавин сая нэг зуун мянга арван)	<b>50,100,010.00</b> (тавин сая нэг зуун мянга арван)	